



СЕКЮРИТИЗ
ҮЦК

ГАДААД ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2022.05.09-2022.05.13



ГАДААД ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2022.05.13-ны after trading session байдлаар

АНУ	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	Он гарснаас хойш
DOW	32,121.00	-0.23%	-0.39%	-6.66%	-6.43%
S&P 500	4,073.04	-0.29%	0.57%	-8.60%	-3.59%
NASDAQ	12,560.00	-0.15%	1.60%	-10.98%	-6.98%
Европ	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	Он гарснаас хойш
GB100	7,418.00	2.56%	0.41%	-2.60%	5.32%
DE40	14,028.00	2.10%	2.59%	-0.96%	-9.01%
FR40	6,363.00	2.52%	1.67%	-3.44%	-0.35%
IT40	24,048.00	2.05%	5.32%	-2.34%	-3.28%
ES35	8,338.00	1.68%	0.19%	-4.15%	-8.83%
Ази	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	Он гарснаас хойш
JP225	26,573.00	0.55%	-1.44%	-2.06%	-5.24%
SHANGHAI	3,091.00	0.20%	2.89%	-3.27%	-12.13%
CSI 300	3,997.00	0.22%	3.11%	-4.04%	-22.89%
CH50	13,353.16	0.43%	3.17%	-3.32%	-24.14%
SENSEX	52,794.00	-0.26%	-3.72%	-7.65%	8.33%
Эрчим хүч	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	Он гарснаас хойш
Газрын тос (Crude Oil)	109.48	-0.91%	6.18%	1.16%	65.17%
Газрын тос (Brent)	110.47	-0.97%	4.19%	-1.39%	58.91%
Байгалийн хий	7.8020	1.81%	11.16%	-1.86%	151.21%
Шатахуун	3.9427	-0.38%	8.17%	17.31%	82.52%
Нүүрс	393.00	0.38%	3.56%	25.16%	296.97%
Түүхий эд	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	Он гарснаас хойш
Алт	1,812.85	0.08%	-2.21%	-8.37%	-2.85%
Мөнгө	21.101	0.13%	-3.11%	-18.29%	-25.06%
Зэс	4.1570	-0.29%	-0.78%	-13.36%	-11.87%
Бонд	Өгөөж	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	Он гарснаас хойш
АНУ	2.9076	0.0200	-0.12%	0.05%	1.27%
Англи	1.7470	0.0470	-0.25%	-0.14%	0.89%
Япон	0.2440	0.0040	0.00%	0.00%	0.17%
Герман	0.9470	0.0780	-0.19%	0.11%	1.07%
Швейцар	0.7750	0.0370	-0.24%	-0.08%	0.97%

Эх сурвалж: Trading economics

Хөрөнгийн зах зээл дээрх уналт хэдий болтол үргэлжлэх вэ?

S&P 500 индекс 2022 он гарснаас хойш хориод хувь унаад байгаа нь ойрын 90 жилд тохиогоогүй хамгийн муу жилийн эхлэл байлаа.

Одоогоор хөрөнгийн зах зээл дээр нөлөөлж буй гол хүчин зүйлс бол яахын аргагүй инфляцын түвшин, хатуу мөнгөний бодлого, олон улсын геополитикийн асуудлууд байна. Эдгээр тодорхой бус байдлаас улбаалан хэдий эдийн засгийн суурь үзүүлэлт болон компаниудын санхүүгийн үзүүлэлт сайн байгаа ч хөрөнгийн зах зээлийн үнэлгээ буурч байгаа нь цаашид баавгайн зах зээл үргэлжилнэ гэсэн хүлээлтийг үүсгэж байна.

Хүнд давааны ард гарсан ч инфляцын түвшин тодорхой бус байдалд нөлөөлсөөр байна


Өнгөрсөн 7 хоногийн хэрэглээний үнийн индексийн мэдээгээр инфляцын түвшин буурах хандлагад орох эсэхийг хүлээж байсан боловч хангалттай хэмжээнд буураагүй нь төв банкыг цаашид хатуу мөнгөний бодлого баримтлах үндэслэл болсоор байна.

4 сард хэрэглээний үнийн индекс 8.3%-тай гарсан нь өнгөрсөн сарын 8.5%-иас буурсан ч гол инфляцын индекс 0.6%-иар өссөн нь үйлчилгээний өртөг нэмэгдсэнтэй холбоотойгоор сүүлийн 3 сарын хамгийн өндөр өсөлт байжээ.

Өсөлтийг задалж үзвэл, түрээс 0.6%-иар, агаарын тээврийн зардал 18.6%-иар өсжээ. Орон сууцны үнэ богино хугацаандаа өсөх хандлагатай байгаа ч зээлийн хүү хурдтай өсөж байгаа нь цаашид байрны үнэ буурахад нөлөөлж болохоор байна.

Хэрэглэгчид үйлчилгээ их авах болон нийлүүлэлтийн гинжин холбоо сайжирч байгаа нь бараа таваарын инфляц буурахад нөлөөлж, цаашид ч буурах хандлагатай.

АНУ-ын инфляцын түвшин



Эх сурвалж: www.edwardjones.com

Хөрөнгийн зах зээлийн сэргэлтийг тогтоох жагсаалт

1. Инфляцын түвшин дээд цэгтээ хүрсэн ба цаашид буурах хандлагатай болсон. **Биелэгдээгүй.**
Сүүлийн үед гарсан мэдээнээс харахад инфляцын түвшин дээд цэгтээ хүрсэн харагдаж байгаа боловч сард 0.6%-иар өсөж байгаа нь инфляцыг оны эцэс гэхэд 4.7% хүрнэ гэж таамагласан нь төв банкны зорилтот түвшнээс 2 дахин их бөгөөд цаашид бодлогын хүүг өсгөх үндэслэл болж өгч байна.
2. Эдийн засаг болон компаниудын санхүүгийн үзүүлэлт сайн байгаа эсэх? **Биелэгдсэн.**
Худалдан авалтын болон үйлдвэрлэлийн индекс өсөх трендтэй болон компаниудын ашиг энэ жил 9% өсөх таамагтай байгаа нь дээрх шаардлагыг хангаж байна.
3. Хөөсөрсөн зах зээлийн үнэлгээ хагарсан. **Биелэгдсэн.**
S&P 500 индексийн үнэ ханшийн харьцаа өнгөрсөн жилийн оргил цэгээс 30%-иар унаад байна. Энэ нь ХНС-ийн бодлогын хүүг нэмснээс хойш хөрөнгийн зах зээл дунджаар 20% унадаг зүй тогтлоос аль хэдий нь давсан нь гол уналт дуусаж байгаагийн дохио гэж харж болохоор байна.
4. Зах зээлийн цаашдын түгээмэл хандлага сөрөг байх. **Биелэгдээгүй.**
Яг одоогоор зах зээлийн сөрөг хандлага давамгайлж байгаа нь AAI санал асуулгаар 2008 оны Дэлхийн Санхүүгийн Хямралын үетэй ойролцоо хэмжээнд хүрсэн гэжээ. VIX индекс 33 нэгж дээр байгаа нь хэлбэлзэл өндөр байгааг илэрхийлж байна.

Дээрх 4 жагсаалтаас хоёр нь биелэгдсэн нь энэ удаагийн баавгай зах зээл дуусах ойртож байгааг илтгэж байгаа боловч эрсдэл-өгөөжийн харьцаа хөрөнгө оруулагчдад ашигтай болтол уналт үргэлжлэхээр харагдаж байна.

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Apple компанийн хувьцаа баавгай зах зээлд орсон нь авах боломж мөн үү?

- Apple компанийн хувьцаа 1-р сарын оргил үеийн ханшаасаа 20% унаад байна
- Уг компани нь эдийн засгийн уналтаар тогтвортой байдаг хувьцаануудын нэг
- Apple-ийн тайлан дээрх бэлэн мөнгөний дүн өндөр байгаа нь бас нэг эерэг хүчин зүйл болж өгч байна

АНУ-ын хамгийн өндөр зах зээлийн үнэлгээтэй компани болох Apple-ийн хувьцааны ханш өнгөрсөн 7 хоногт 1-р сарын үеийн оргил цэгээсээ 20 хүртэл хувь унасан нь цаашид буурах дохио болж өгч байна. Энэхүү уналт нь өнгөрсөн Пүрэв гарагт Saudi Agamco компанийн үнэлгээг 2.43 их наяд доллар байснаар дэлхийн хамгийн өндөр зах зээлийн үнэлгээтэй компани болоход хүргэсэн.

Apple-ийн хувьцааны ханш



Энэхүү уналтыг хэдий хүртэл үргэлжлэхийг хэлж мэдэхгүй боловч Apple компанийн хувьцааг өсөхөд нөлөөлөх хэд хэдэн хүчин зүйлс байна. Жишээлбэл компанийн олон улсад эзлэх гар утасны зах зээлийн байр суурь сайтай тул санхүүгийн хувьд эдийн засгийн хүндрэлийг даван туулахад хангалттай юм.

Энэ улирлын санхүүгийн тайлан сайн гарсан

Энэ улирлын тайлангаар тус компанийн нийт ашгийн маржин 43% гарсан нь цар тахлын үеийн дээд түвшин болох 38%-иас ч илүү байсан юм. Энэ нь Iphone утасны илүү үнэтэй 5G загварын борлуулалт сайн байсантай холбоотой. 3 сард уг компанийн борлуулалт 97.3 тэрбум доллар байсан нь баярын сарыг оруулахгүйгээр хамгийн их борлуулалттай сар байсан бол өнгөрсөн 12-р сард 124 тэрбум доллар буюу хамгийн их борлуулалт хийжээ.

Эх сурвалж: www.edwardjones.com

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Apple-ийн бэлэн мөнгөний хуримтлал нь тодорхой бус байдалтай үеийг даван туулахад гол үүрэг гүйцэтгэхээр байна. Компани 200 тэрбум доллартой бөгөөд энэ нь дэлхийн хамгийн их мөнгөн хөрөнгийн нөөцтэй компани болгож байгаа тул хувьцааны ханш унах үед халааслах зарчмаар буцаан худалдан авах бүрэн боломжтой. Хувьцаа халааслах нь нийт эргэлтэд байгаа хувьцааны тоог бууруулж, нэгж хувьцаанд ногдох ашгийг өсгөдөг тул хөрөнгө оруулагчдад ээлтэй мэдээ болж өгдөг.

Warren Buffet энэхүү хөрөнгө оруулалтын арга барилыг ашигладаг бөгөөд тэрээр 2016 оноос хойш Apple компанийн хувьцааг авсан ба одоогоор 159 тэрбум долларын хөрөнгө оруулалт хийсэн. Энэ нь Warren Buffet-ийн хөрөнгө оруулалтын багцын 40%-ийг дангаараа бүрдүүлж байгаа тул Apple-ийн хувьцааг урт хугацаандаа өснө гэдэгт итгэлтэй байгаа харуулж байна.

Дүгнэлт

Apple компанийн хувьцааг хэдэн доллар хүртэл унахыг хэлэхэд хэцүү ч урт хугацаандаа салбартаа тэргүүлэгч, сайн санхүүгийн үзүүлэлттэй энэхүү компанид хөрөнгө оруулах боломж болж байгааг харвал илүүдэхгүй болов уу.

Эх сурвалж: www.edwardjones.com



СЕКЮРИТИЗ
ҮЦК